



## БӨМБӨГТЭЙ ДАСГАЛ ТОГЛООМ АШИГЛАН, БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.Пүрэвдорж<sup>а</sup><sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: puujee@msue.edu.mn

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Энэхүү өгүүлэл нь бөмбөгтэй дасгал тоглоомоор дамжуулан бага насны хүүхдийн суралцахуйг дэмжих онолын үндсийг судалсан болно. Л.Выготскийн соёл-сэтгэлзүйн онол, Ж.Пиаже-ийн танин мэдэхүйн хөгжлийн онол, Ж.Бандурагийн нийгмийн суралцахуйн онол, Брунерийн бүтээлч суралцахуйн онол зэрэг боловсролын гол онолуудыг судалж, бөмбөгтэй дасгал тоглоомын боловсролын ач холбогдлыг шинжилсэн. Судалгаагаар энэ төрлийн тоглоомууд нь хүүхдийн бие бялдрын зохицуулалт, орон зайн мэдрэмж, анхаарал төвлөрүүлэх чадвар, нийгмийн харилцааны чадварыг сайжруулдаг болох нь батлагдсан. Иймээс, бөмбөгтэй дасгал тоглоом нь танин мэдэхүй, нийгмийн болон биеийн хөгжилтэй хослон хүүхдийн суралцах үйл явцыг дэмжих үр дүнтэй сурган хүмүүжүүлэх арга хэрэгсэл болдог.

### Түлхүүр үг

Бага насны хүүхэд, суралцахуй, бөмбөгтэй дасгал тоглоом, танин мэдэхүйн хөгжил, нийгмийн харилцаа, бие бялдрын хөгжил, сургалтын арга зүй

### Удиртгал

Өдгөө боловсролын салбарт бага насны хүүхдийн суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил, шинэчлэл хийгдсээр байна. Энэ хүрээнд хүүхдийн суралцах идэвх, амжилтыг нэмэгдүүлэх, нийгэмшил, сэтгэн бодох, хэл яриа болон хөдөлгөөний ур чадварыг хөгжүүлэхэд тулгуурласан биеийн тамир, хөдөлгөөний тоглоом, дасгалуудыг боловсруулан хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой. Тэдгээрээс бөмбөгтэй дасгал тоглоомыг ашиглан, бага насны хүүхдийн суралцахуйд үзүүлэх нөлөө, арга зүйн талаарх онол, үзэл баримтлалыг судалсан.

Тоглоомын арга зүйг ашигласнаар хүүхдүүдийн танин мэдэхүй, бие бялдрын хөгжил, багаар ажиллах, харилцааны ур чадвар, орон зайн ойлголт илт сайжирдаг төдийгүй суралцах үйл явц илүү сонирхолтой, үр дүнтэй болдог.

Бага насны хүүхдийн сурлагын амжилт, бие бялдрын хөгжил нь тэдний танин мэдэхүйн чадвар, сэтгэл зүйн бэлэн байдалд шууд нөлөөлдөг тул тоглоомын аргаар сургах нь чухал гэж үзсэн. Тухайлбал, бөмбөгтэй дасгал тоглоом нь хөдөлгөөн, бие бялдрын идэвхжилийг нэмэгдүүлэхээс гадна хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлдөг болох нь олон судалгаагаар батлагдсан байдаг. Энэхүү илтгэлд бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйн онол, үзэл баримтлалыг тодорхойлон, бага насны хүүхдийн суралцахууд үзүүлэх үр нөлөөг судалснаар уг сэдвийн ач холбогдлыг тодруулж байгаа болно.

## **Судалгааны зорилго**

Бөмбөгтэй дасгал тоглоомыг ашиглан, бага насны хүүхдийн суралцахууг дэмжих арга зүйн онолын үндсийг тодорхойлох, тэдгээрийн практик хэрэглээ, үр дүнг шинжлэх

## **Судалгааны зорилт**

- Бөмбөгтэй дасгалын арга зүйг тодорхойлох
- Бөмбөгтэй дасгалын онол, арга зүйг тодруулах
- Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх

## **Судалгааны асуудал**

Бага насны хүүхдийн суралцахууг дэмжих биеийн хөдөлгөөн, дасгал тоглоом нь цогц, нэгдмэл, иж бүрэн бус байгаа тул бөмбөгтэй дасгалыг ашиглан, бага насны хүүхдийн суралцахууд үзүүлэх нөлөөг тодруулахын тулд суралцахууг дэмжих арга зүйн онол, үзэл баримтлалд энэ талаарх үзэл санаа туссаныг тодруулах асуудал урган гарсан болно.

## **Судалгааны арга:**

- Баримт бичгийг шинжлэн судлах арга

## **Хамрах хүрээ**

- **Бага насны хүүхдийн суралцахуйн онол:** Ж.Пиаже, Л.Выготский, Ж.Брунер, Х.Гарднер зэрэг эрдэмтдийн суралцахуйн онолууд
- **Бөмбөгтэй дасгал тоглоомын боловсролын болон хөгжлийн талаарх судалгаа:** Хөдөлгөөний хөгжил, танин мэдэхүйн хөгжил, харилцааны ур чадвар зэрэг хүүхдийн олон талт хөгжлийг дэмжих боломжийг судалсан бүтээлүүд

## **Судалгааны ажлын онолын үндэс**

Бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүй нь хөдөлгөөнөөр дамжуулан, хүүхдийн суралцахуй, танин мэдэхүй болон бие бялдрын хөгжилд нөлөөлөх үр дүнтэй сургалтын нэгэн хэлбэр юм. Энэ нь хүүхдийн анхаарал төвлөрөлт, хөдөлгөөний

зохицуулалт, орон зайн мэдрэмжийг хөгжүүлэхээс гадна багаар ажиллах чадвар, нийгмийн харилцааны ур чадварыг хөгжүүлнэ.

### **Бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйн үндсэн зарчим:**

- **Хөдөлгөөн ба суралцахуйг уялдуулах:** Биеийн хөдөлгөөн нь хүүхдийн тархины үйл ажиллагааг идэвхжүүлж, суралцах үйл явцыг дэмждэг тул бөмбөгтэй дасгал нь хүүхдийн сурах чадварыг сайжруулна.
- **Багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх:** Бөмбөгтэй тоглоом нь багийн ажиллагааг шаарддаг тул хүүхдүүдийг бие биетэйгээ харилцаж, асуудлыг хамтдаа шийдвэрлэхэд тусална.
- **Мэдрэмжийг хөгжүүлэх:** Бөмбөгтэй тоглоом нь хүүхдийн гар, нүдний зохицуулалт, орон зайн мэдрэмжийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь хөл, гар, биеийн хөдөлгөөнийг зохицуулах чадварыг сайжруулж, биеийн тэнцвэрийг хадгалах, орон зайд зөв хөдөлгөөн хийхэд сургадаг.
- **Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих:** Бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүй нь хүүхдийн ой тогтоолт, асуудал шийдвэрлэх чадвар, логик сэтгэлгээг сайжруулахад чиглэнэ. Бөмбөгийг зөв чиглэлд шидэх, хүлээн авах, багийн гишүүдтэйгээ зөв харилцах зэрэг нь эдгээр чадваруудыг дэмждэг.

Эдгээр арга зүй зарчмууд нь хүүхдийн суралцах чадварыг хөгжүүлэхэд, биеийн хөдөлгөөн болон нийгмийн харилцааны чадваруудад чухал нөлөөтэй тул боловсролын түвшин бүрт өргөн хэрэглэсээр байна.

Бага насны хүүхдийн суралцах үйл явц нь тэдний бие махбодын хөдөлгөөн, танин мэдэхүйн хөгжил, нийгмийн харилцаатай нягт уялдаа холбоотой байдаг. Биеийн идэвхтэй хөдөлгөөн нь хүүхдийн оюун санааны хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд хөдөлгөөнт тоглоомууд нь энэ үйл явцыг эрчимжүүлдэг гэж судлаачид үзжээ. Тэр дундаа бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдийн орон зайн мэдрэмж, анхаарал төвлөрөлт, шийдвэр гаргах зэрэг чадваруудыг хөгжүүлэхээс гадна хамтран ажиллах, нийгмийн харилцааны ур чадварыг сайжруулахад тусалдаг. Илтгэлд чухалчилж буй бага насны хүүхдийн суралцахуйн онцлог болон бөмбөгтэй дасгал тоглоомын харилцан хамаарал, тэдгээрийн суралцах чадварын хөгжилд үзүүлэх нөлөөллийг онолын үндэстэй тайлбарлахад дараах ойлголтуудад тулгуурлана.

### **Бага насны хүүхдийн суралцахуйн онцлог**

Бага насны хүүхдийн суралцахуйн онцлог нь тэдний физиологи, танин мэдэхүй, нийгэмшил, сэтгэл зүйн хөгжлийн явцад ихээхэн нөлөөлдөг. Эрдэмтэд “Энэхүү үе шатанд хүүхэд голчлон мэдрэхүй, хөдөлгөөн, хүлээн авах чадвараар дамжуулж, шинэ мэдээлэл, ур чадварыг суралцдаг” гэж үзээд, суралцахуйн онцлог болон хөдөлгөөний уялдаа хамаарлыг:

- Ж.Пиаже болон Л.Выготский нар бага насны хүүхэд мэдлэгийг биеэрээ хийж туршиж, оролцож суралцдаг. Аливаа үйлдэлд оролцох замаар тэдний ойлголт, ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайжирдаг хэмээн хүүхдийн танин мэдэхүйн хөгжил талаас нь,
- Л.Выготский хүүхдийн биеийн хөдөлгөөн, гар сарвууны ажиллагаа зэрэг

нь суралцахуйн чухал хэсэг байдаг. Биеэрээ хийх үйлдлүүд нь хүүхдийн сэтгэхүйн чадварыг хөгжүүлдэг гэж үзэн, хүүхдийн биеийн хөгжил талаас нь,

- Л.Выготский социокультурын онолдоо бага насны хүүхэд хамт олонтойгоо хамтран суралцах явцад хамгийн үр дүнтэй хөгждөг. Хамтын ажиллагаа, нийгмийн харилцаа нь тэдний суралцах чадварыг хурдасгадаг хэмээн хүүхдийн нийгмийн харилцаа талаас нь тайлбарласан байна.

Сургуулийн бага насны хүүхдийн суралцахуйн онцлог ба бөмбөгтэй дасгал тоглоомын харилцан хамаарал

Суралцахуйн онцлог	Бөмбөгтэй дасгал тоглоомын нөлөө	Суралцах чадварын хөгжил үзүүлэх нөлөө
Хөдөлгөөнөөр дамжуулан сурах (бие мах бодийн оролцоо)	Биеийн хөдөлгөөн болон орон зайн баримжааг хөгжүүлж, тэднийг суралцах үйл явцад идэвхжүүлдэг.	Хүүхэд хөдөлгөөнөөр дамжуулан ойлгож, ойлгож суралцах чадвар нь сайжирдаг.
Танин мэдэхүйн хөгжил (сэтгэхүй, ой тогтоолт)	Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдийн ой тогтоолт, анхаарал төвлөрөл, шийдвэр гаргах чадварыг сайжруулдаг	Танин мэдэхүйн хөгжил, бодож шийдвэрлэх чадвар нэмэгдэнэ.
Нийгмийн харилцаа (хүмүүстэй хамтран суралцах)	Багийн тоглолт, хамтын ажиллагаа шаардлагатай учир хүүхдийн нийгмийн харилцааны чадварыг хөгжүүлдэг.	Хамтран ажиллах, харилцах чадвар дээшилнэ.
Хамтын ажиллагаа (харилцааны чадвар)	Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдийг хамтран ажиллах, дүрэм журмыг дагаж мөрдөхөд сургадаг.	Харилцаа, хамтын ажиллагааны чадвар сайжирна.
Өөрийгөө илэрхийлэх болон бүтээлч байдал	Тоглолтын явцад хүүхэд өөрийгөө чөлөөтэй илэрхийлж, бүтээлч сэтгэлгээ нь хөгждөг	Хүүхдийн өөрийгөө илэрхийлэх чадвар болон бүтээлч сэтгэлгээ хөгждөг.

Бага насны хүүхдийн суралцахуйн онцлог болон бөмбөгтэй дасгал тоглоом нь нэг нэгэнтэйгээ нөхцөлдөж бас нэг нь нөгөөгөө нөхөн хөгжүүлэх онцлогтой. Танин мэдэхүйн хөгжил, бие бялдрын үйл ажиллагаа хоёр нь нарийн уялдаа холбоотой байдаг.

Тухайлбал, бөмбөгийг барих, шидэх үйлдэл нь хүүхдийн гар сарвууны чадварыг хөгжүүлж, анхаарал төвлөрөлт, шийдвэр гаргах чадварыг сайжруулдаг бол хамтран тоглох явцад нийгмийн харилцааны чадвар сайжирч, багийн ажиллагаанд суралцдаг. Бөмбөгтэй дасгал тоглоомыг сургалтын арга зүйд ашиглахад суралцахуйн онолуудтай нийцэж буйг судлахдаа Ж.Пиаже, Л.Выготский, Ж.Брунер зэрэг эрдэмтдийн онолтой холбож тайлбарласан болно.

## Жан Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онол

Ж.Пиажегийн онолоор хүүхдийн танин мэдэхүйн хөгжил тодорхой үе шатуудаар дамждаг ба тэд өөрийн туршлага, хэмнэлээр суралцдаг. Бөмбөгтэй дасгал тоглоомыг сургалтад ашиглах нь Ж.Пиажегийн үзэл онолтой бүрэн нийцэж байна.

- **Мэдлэгийг бүтээх:** Ж.Пиаже хүүхдүүдийг орчноо судалж, туршлага хуримтлуулж байж сурдаг гэж үзсэн. Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдүүдийг хөдөлгөөнөөр дамжуулан мэдлэгийг өөрсдөө бүтээх боломжийг олгодог. Жишээлбэл: Бөмбөгийг шидэх, барих явцад хүүхдийн орон зайн ойлголт, ой тогтоолтын чадвар хөгжинө.
- **Танин мэдэхүйн төвлөрөл:** Бөмбөгтэй тоглоомоор дамжуулан, хүүхэд анхаарлаа төвлөрүүлж, тооцоолж, асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлж буй нь Ж.Пиажегийн үе шаталсан хөгжлийн зарчимд нийцэж байна.
- **Лев Выготскийн социокультурын онол**  
Л.Выготский хүүхдийн суралцах үйл явц нь нийгмийн харилцаа, хамтын ажиллагаагаар дамжин өрнөдөг хэмээн үзсэн. Бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүй нь Выготскийн онолтой олон талаар нийцдэг.  
Л.Выготский хүүхэд бие даан суралцаж чадахгүй байгаа зүйлийг насанд хүрэгчдийн болон чадварлаг хүүхдийн тусламжтайгаар сурч чадна гэж үзсэн. Бөмбөгтэй дасгал тоглоом нь хамтран ажиллаж, бие биедээ тусалж, харилцан суралцах боломжийг олгодог. Тиймээс энэ тоглоом нь хүүхдийн хөгжлийн ойрын бүсийг дэмжинэ.
- **Хамтын ажиллагаа:** Бөмбөгтэй тоглоом нь багийн ажиллагаа, харилцааны ур чадвар, хамтын шийдвэр гаргалтыг хөгжүүлдэг тул Л.Выготскийн онолд нийцэж байна. Бусадтай хамтран ажиллах нь хүүхдийн суралцах үйл явцыг илүү үр дүнтэй болгодог.

## Ховардын оюун ухааны онол

Ховард Гарднерийн оюун ухааны онолоор хүүхдийн оюуны олон чадварыг хөгжүүлж болдог гэж үзсэн. Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдийн дараах оюуны чадваруудыг зэрэг хөгжүүлдэг.

- Бөмбөгтэй дасгал тоглоомоор дамжуулан, хүүхдийн орон зайд чиглэсэн үйлдлүүдийг сайжруулж, орон зайн ойлголтыг нь хөгжүүлдэг.
- Биеийн хөдөлгөөнтэй холбоотой дасгалууд нь хүүхдийн бие махбодын чадамжийг хөгжүүлж, асуудал шийдвэрлэх, хамтын ажиллагаа зэрэг чадварыг дэмждэг.

## Дэвид Колбын бодит суралцах онол

Колбын онолоор хүүхэд туршлагаар дамжуулан суралцдаг. Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдүүдийг туршлагаар суралцах боломжийг олгодог бөгөөд суралцах үйл явц дараах алхмуудаар өрнөдөг.

- **Туршлага хуримтлуулах:** Бөмбөгтэй тоглоомоор хүүхэд бодитоор туршиж, үйл ажиллагаа явуулж суралцана.
- **Анализ хийх:** Хүүхэд тоглоомын явцад гарсан үр дүнг үнэлж, өөрийн үйл явцаа дүгнэнэ.

- **Шинэ мэдлэг бүтээх:** Туршилтын үр дүнг дүгнэж, дараагийн тоглоомын үеэр шинэ арга барил хэрэглэх замаар мэдлэгээ хөгжүүлнэ.

Эдгээр онолуудтай уялдуулан, бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйд ашиглах нь хүүхдийн танин мэдэхүй, бие бялдрын хөгжилд ихээхэн ач холбогдолтой бөгөөд суралцах үйл явцын үр дүнг сайжруулахад чухал хувь нэмэр оруулдаг.

### Суралцахуйн онолууд ба бөмбөгтэй дасгал тоглоомын нийцэл

Суралцахуйн онол	Бөмбөгтэй дасгал тоглоомын нийцэл	Сургалтын үйл явцад оруулах хувь нэмэр
Л.Выготскийн нийгэм соёлын онол	Нийгмийн харицаагаар суралцах, хамтын ажиллагаа, ойрын хөгжлийн бүсийг идэвхжүүлэх боломж	Хүүхдүүд нийгмийн харилцаагаар дамжуулан илүү үр дүнтэй суралцах, хамтран шийдвэр гаргах, сурах үйл явцад хамт олноороо оролцох чадвар сайжирна.
Ж.Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн онол	Биеийн хөдөлгөөн, туршлагаар дамжуулан танин мэдэхүйг хөгжүүлэхэд түлхэц өгнө.	Хүүхдүүд туршлагаар дамжуулан танин мэдэхүйн хөгжлийг дэмжиж, өөрийн мэдэрхүй, оюун ухаанаа хөгжүүлэх боломж
Х.Гарднерын олон оюун ухааны онол	Орон зай, биеийн хөдөлгөөнөөр суралцах чадваруудыг хөгжүүлэхэд онцгой анхаарна.	Хүүхдийн олон төрлийн оюун ухааныг хөгжүүлэх боломжтой тул хувь хүний онцлогт нийцсэн сургалтын арга зүйг дэмжинэ.
Д.Колбын туршлагад суурилсан суралцахуйн онол	Биеийн хөдөлгөөн, практик туршлагаар дамжуулан суралцах үйл явцыг дэмжинэ.	Хүүхэд бие даасан болон бодит туршлагаар суралцах үйл явцыг дэмжиж, мэдлэгийг практикт хэрэглэхэд тусална.

### Х.Гарднерийн онол нь бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйн үндэс болох нь

Гарднерийн олон талт оюун ухааны онолыг бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйн онолын үндэс болгох дараах үндэслэлийг дэвшүүлж байна. Үүнд:

- **Суралцах олон чадварыг хөгжүүлэх** Гарднерийн онолын гол санаа нь хүүхэд бүрийн оюун ухааны хөгжил өөр өөр бөгөөд сурах арга барил нь ч олон янз байдаг. Бөмбөгтэй дасгал тоглоом нь энэ үзэл баримтлалтай шууд нийцэж байна. Биеийн хөдөлгөөн, орон зай, хамтын ажиллагааны ур чадварууд нь хүүхдийн оюуны чадамжийг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй. Энэ нь бөмбөгтэй дасгал тоглоомыг хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих арга зүй болгоход тулгуур үндэс болно.
- **Биеийн кинестетик оюун ухаан ба сургалтын гол хэрэгсэл болгох** Гарднерийн онолын нэг чухал хэсэг болох биеийн-кинестетик оюун ухаан нь хүүхдийн биеийн хөдөлгөөнөөр дамжуулан, суралцахуйг дэмждэг. Бөмбөгтэй дасгал тоглоом нь хөдөлгөөнийг түлхүү ашиглаж, хүүхдийн бие, сэтгэл, оюуныг нягт уялдаатай хөгжүүлдэг. Иймээс энэхүү дасгал тоглоом нь Гарднерийн үзэл санаанд бүрэн нийцэж, сургалтын гол арга хэрэгсэл болж чадна.

- **Орон зайн сэтгэлгээ ба суралцах орчныг хөгжүүлэх**

Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдүүдийн орон зайн сэтгэлгээг хөгжүүлдэг. Орон зайн мэдрэмж, асуудал шийдвэрлэх ур чадваруудыг дасгал тоглоомоор дамжуулан хөгжүүлдэг тул энэ нь Гарднерийн онолын **орон зайн оюун ухааны** талаарх санаатай нийцдэг. Тухайлбал, бөмбөгний хурд, байрлал, чиглэл зэрэг элементүүдээр орон зайн сэтгэлгээ хөгждөг.

- **Нийгмийн болон хамтын ажиллагааны ур чадварыг хөгжүүлэх**

**Хамтын ажиллагааны оюун ухаан** нь Гарднерийн онолын нэг хэсэг бөгөөд энэ нь хүүхдүүдийн бусадтай харилцах, хамтран ажиллах, бусадтай ойлголцох чадваруудыг дэмждэг. Бөмбөгтэй дасгал тоглоом нь ихэнх нь багийн тоглоом хэлбэртэй учраас хүүхдүүдийн нийгмийн ур чадварыг хөгжүүлж, хамтын ажиллагаа, зохицуулалт, харилцааны ур чадварыг сайжруулна.

- **Хувь хүний оюун ухаан хөгжүүлэх**

Бөмбөгтэй дасгал тоглоом нь хүүхдэд өөрийгөө ойлгох, илэрхийлэх боломж олгодог тул Гарднерийн онолын хувь хүний оюун ухааны хөгжлийн санаатай уялдаж байна. Хүүхдүүд энэ тоглоомоор дамжуулан, өөрсдийгөө таньж мэдэн, зорилгодоо хүрэхийн тулд өөрийгөө хянах чадвараа сайжруулдаг. Эцэст нь дүгнэхэд Гарднерийн олон талт оюун ухааны онол нь бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйг бүх талын (бие махбод, сэтгэл санаа, нийгмийн харилцаа, өөрийгөө танин мэдэхүй) оюун ухааны хөгжлийг дэмжих хүчтэй хэрэгсэл болгож өгч байна.

## Дүгнэлт

1. Бөмбөгтэй дасгал тоглоом нь бага насны хүүхдийн суралцах үйл явцад олон талын эерэг нөлөө үзүүлдэг үр дүнтэй арга хэрэгсэл юм.
2. Гарднерийн онолыг бөмбөгтэй дасгал тоглоомын арга зүйн үндсэн онол гэж үзэх нь маш тохиромжтой бөгөөд хүүхдийн олон төрлийн чадамжийг хөгжүүлэх боломж олгох сургалтын шинэлэг арга зүй болж чадна.
3. Хүүхдийн танин мэдэхүй, нийгмийн харилцаа, бие бялдрын хөгжилд онцгой ач холбогдолтой энэхүү бөмбөгтэй дасгал тоглоомыг сургалтын үйл явцад ашиглах нь хүүхдийн суралцах чадварыг цогцоор нь хөгжүүлэх үр дүнтэй арга зүй болохыг судалгааны үр дүн баталж байна.

## Талархал

Энэхүү судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний дэмжлэг, оролцоогүйгээр энэ судалгаа үр дүнтэй хэрэгжих боломжгүй байсан билээ.

## Ном зүй

Bandura, A. (1977). *Social learning theory*. Prentice Hall.

Bruner, J. S. (1966). *Toward a theory of instruction*. Harvard University Press.

Grissom, J. B., & Hogle, P. B. (2015). The impact of physical activity on cognitive development in early childhood. *Journal of Child Psychology and Psychiatry*, 56(9), 999-1006. <https://doi.org/10.1111/jcpp.12321>

Kim, H. S., & Park, J. Y. (2018). Effects of physical exercise games on cognitive development in preschoolers. *Early Childhood Education Journal*, 45(2), 123-135. <https://doi.org/10.1007/s10643-017-0886-7>

Piaget, J. (1954). *The construction of reality in the child*. Basic Books.

Vygotsky, L. S. (1978). *Mind in society: The development of higher psychological processes*. Harvard University Press.

Weiss, M., & Smith, A. (2013). Physical activity and child development: Evidence for active learning. *Child Development Perspectives*, 7(4), 344-351. <https://doi.org/10.1111/cdep.12052>

Meinhardt, I., & Bauer, P. (2017). Motor skills and cognitive performance in preschool children: The role of physical activity. *European Journal of Psychology of Education*, 32(3), 279-298. <https://doi.org/10.1007/s10212-017-0357-9>

## ANALYSIS OF THEORETICAL CONCEPTS AND PRINCIPLES OF SUPPORTING EARLY CHILDHOOD LEARNING THROUGH BALL EXERCISE GAMES

<sup>a</sup>Purevdorj D.

<sup>a</sup>Master, Lecturer, Teachers school, MNUE

Corresponding author: puujee@msue.edu.mn 

### Abstract

This paper examines the theoretical foundations of supporting early childhood learning through the use of ball-based exercise games. Drawing on key educational theories, including Vygotsky's socio-cultural theory, Piaget's cognitive development theory, Bandura's social learning theory, and Bruner's constructivist theory, the educational value of ball-based exercise games is analyzed. Research shows that such games enhance children's physical coordination, spatial awareness, attention focus, and social interaction skills. Therefore, ball-based exercise games serve as an effective pedagogical tool that integrates cognitive, social, and physical development, supporting children's overall learning process.

### Keywords

Early childhood, learning, ball-based exercise games, cognitive development, social interaction, physical development, teaching methodology